



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/25

Мандалговь

Аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлагуудын 2018 оны
үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, 40.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 11.1, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 01 сарын 21-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авч тэргүүн байр эзэлсэн "Улсын бүртгэлийн хэлтэс"-ийг "Өргөмжлөл" 1000000 (Нэг сая) төгрөгөөр, дэд байр эзэлсэн "Байгаль орчин, аялал жуулчлалын газар"-ыг "Өргөмжлөл" 800000 (найман зуун мянган) төгрөгөөр, гутгаар байр эзэлсэн "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар"-ыг "Өргөмжлөл" 500000 (таван зуун мянган) төгрөгөөр, тус тус шагнасугай.

Гурав. Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авсан Улсын бүртгэлийн хэлтсийн даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний, Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргад 1 сарын үндсэн цалингийн 90 хувь, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргад 1 сарын үндсэн цалингийн 80 хувь эхний 1, 2, 3-р байр эзэлсэн агентлагийн хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн болон Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар, Статистикийн хэлтэс, Шүүхийн Шинжлэх

488010100

гүйцэтгэх газар зэрэг агентлагийн дарга, Хяналт- шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд 1 сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн сандаа багтаан олгохыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Шагналд шаардагдах 2570000 (Хоёр сая таван зуун далан мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Тав. Хяналт шинжилгээний үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллахыг хэлтэс агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

Зургаа. Үйл ажиллагааны үр дүнгээр "Дутагдалтай" үнэлэгдсэн Биеийн тамир, спортын газрын даргад сануулах шийтгэлийн арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажил зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг сайжруулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа), Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)- нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 15 тоот захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2018 оны үйлжиллээний үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн нэвтрэл

№	Агентлагийн нэрс	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт										Хэргийн үнэлгээний дүндэж дүн					Хэргийн үнэлгээний дүндэж дүн					Байр	2017/2018 (өсөлт бууралт)
		Хууль тогтоомж тогтоон шийдвэрийн хэрэгжилт	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Амгийн дэргэд хэрэгжилт	Амгийн сайд нартай хэрэгжилт	Яамдын сайд нартай хэрэгжилт	Байгуулсан нэгжүүдэд хэрэгжилт	Хүний ажиллагааны үнэлгээ	Амгийн засаг даргаас байгуулсан нэгжүүдэд хэрэгжилт	Хүний ажиллагааны үнэлгээ	Хүний ажиллагааны үнэлгээ	Хүний ажиллагааны үнэлгээ	Хэргийн үнэлгээний дүндэж дүн	Хэргийн үнэлгээний дүндэж дүн	Хэргийн үнэлгээний дүндэж дүн	Хэргийн үнэлгээний дүндэж дүн	Хэргийн үнэлгээний дүндэж дүн	Хэргийн үнэлгээний дүндэж дүн					
1	УБХэлтэс	95.20	100.0	100.0	100.0	100.0	93.80	93.90	97.00	93.30	95.30	94.85	97.50	95.50	89.00	87.40	92.35	95.33	1	1.79			
2	БОАЖГазар	91.70	92.50	94.70	93.70	93.70	93.15	91.40	100.0	100.0	93.25	96.16	100.0	93.15	96.50	92.85	95.63	94.98	2	-0.43			
3	ГХБХБГазар	95.50	94.00	94.00	91.90	93.85	93.50	95.20	93.00	93.00	93.30	94.00	100.0	94.60	93.50	93.80	95.48	94.44	3	-0.71			
4	МХГазар	92.90	90.00	95.20	92.70	93.20	93.20	100.0	90.00	94.80	94.50	100.0	93.10	96.00	93.30	93.30	95.60	94.27	4	-1.89			
5	ОБГазар	93.70	100.0	90.00	93.43	90.25	91.90	100.0	95.60	94.44	92.50	94.40	91.10	93.30	93.30	92.83	93.56	5	3.12				
6	ХХҮГазар	97.20	93.30	87.30	86.45	90.31	93.75	95.80	92.65	93.13	98.75	99.05	96.85	87.40	95.51	91.70	95.96	90.39	6	0.69			
7	ШШАЛба	85.00	-	70.00	81.67	91.63	96.25	94.63	91.70	93.55	98.75	97.50	93.75	93.82	95.96	90.39	91.15	90.34	7	5.16			
8	Цагдаагийн газар	91.40	90.00	85.00	87.40	83.45	92.00	100.0	88.60	85.1	91.4	97.00	89.30	93.70	84.60	89.04	86.51	90.02	8	1.59			
9	Слалстгийн	92.90	100.0	-	96.45	91.56	75.00	97.63	84.25	87.11	71.25	93.00	92.75	89.04	86.51	90.02	89.70	90.01	9	-0.04			
10	ШШГазар	95.00	85.00	70.00	87.50	91.60	90.83	90.38	82.50	83.00	83.00	82.00	83.00	83.00	83.00	83.00	86.54	88.78	10	2.25			
11	НДХэлтэс	88.30	85.00	100.0	90.00	90.83	90.38	82.50	100.0	83.00	88.97	79.00	89.00	91.25	86.92	86.54	88.78	11	2.25				
12	Татварын хэлтэс	92.00	90.00	90.00	89.25	83.80	83.00	82.00	73.00	84.20	91.00	97.00	83.80	89.10	90.23	87.89	87.89	12	2.20				
13	ҮЦҮОШТэв	88.40	85.00	-	86.70	91.81	92.50	96.50	87.00	91.95	100.0	71.40	78.00	81.50	82.73	87.13	82.73	13	-0.7				
14	ГБХЗХГазар	90.50	94.00	68.00	85.63	90.74	90.00	85.20	85.20	91.49	100.0	85.80	72.50	77.40	83.93	87.01	83.93	14	2.04				
15	БСУГазар	90.00	31.50	83.40	85.88	90.70	95.00	86.70	80.40	88.20	82.50	72.80	98.80	86.40	85.13	86.40	85.13	15	-4.51				
16	СХЗХэлтэс	90.00	70.00	-	83.3	83.40	67.00	100.0	85.80	91.55	94.50	78.10	87.50	76.20	84.08	86.32	84.08	16	-3.11				
17	ЭМГазар	87.50	57.10	84.10	73.33	87.50	91.00	81.00	32.00	83.65	89.00	83.80	92.80	87.00	89.40	85.46	85.46	17	-2.73				
18	ОНӨГазар	90.00	85.00	85.00	88.13	83.72	75.20	81.10	79.40	81.36	86.50	93.30	84.00	75.40	84.80	84.76	84.80	18	2.73				
19	СХААЛба	81.40	-	-	31.40	83.76	95.50	-	72.20	80.82	83.00	96.50	93.00	89.24	91.69	84.64	91.69	19	-3.26				
20	ХХААГазар	84.30	89.30	85.20	84.60	85.98	90.40	84.70	82.00	87.10	88.00	71.00	88.00	75.70	80.68	84.58	80.68	20	-6.03				
21	БСГазар	85.00	85.00	87.10	68.00	81.53	92.21	76.25	100.0	50.70	79.79	48.00	82.30	35.80	51.98	71.10	51.98	21	-12.9				
ДҮН		89.97	87.22	85.88	89.39	88.07	90.37	91.04	94.11	84.36	89.81	89.96	88.69	87.70	84.48	87.71	88.53						

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс